



ЗАМ, ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ  
ИНЖЕНЕР-ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨХ  
“ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

## ТАЙЛБАР БИЧИГ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвийн авто замын  
нарийвчилсан зураг төсөл

УЛААНБААТАР 2017 он



ЗАМ, ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ  
ИНЖЕНЕР-ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨХ  
“ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

## ТАЙЛБАР БИЧИГ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвийн авто замын  
нарийвчилсан зураг төсөл


Захирал

Ерөнхий инженер



У Жан Тэг

Н.Нямсүрэн



УЛААНБААТАР 2017 он



**1.ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ**

**1.1 Үндэслэл**

Хэнтий аймгийн ЗДТГ-ын захиалгаар Хэрлэн сумын төвд хэрэгжих авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулав.

Гэрээт ажилд нийт 9 авто замын зураг төслийн ажил багтаж байна. Үүнд:

- 1) Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвд баригдах 5.396км Их тойруугийн авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл;
- 2) Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвд баригдах Хангамжийн гудамжны 0.97км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл;
- 3) Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвд баригдах Шинэ Өндөрхааны тойргийн 3.701км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл;
- 4) Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3 дугаар баг С-29, С-80, С-78 дугаар байрны урдуур үргэлжлэх 0.71 км авто зам зогсоолын инженерийн нарийвчилсан зураг төсөл;
- 5) Хэнтий аймгийн Хэрлэн сумын төв баригдах Холбооны гудамжны 0.48км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл;
- 6) Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4-р багийн хорооллын доторх 0.764км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл;
- 7) Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3-р баг А-28 дугаар байрны урд талын 0.148км авто замын /зогсоолын хамт/ инженерийн нарийвчилсан зураг төсөл;
- 8) Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвд баригдах Эрчмийн гудамжны 1.203км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл;
- 9) Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5-р баг Сангийн аж ахуйн орон сууцны доторх 0.517км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл;

Авто замуудын байршлыг тоймлон дараах зурагт үзүүлээ.



Зураг 1.



### 1.2 Төсөл хэрэгжих газрын тухай

Хэнтий аймаг нь Монгол орны дорно зүгт орших бөгөөд хойд талаараа Орос улстай хил залгана. Улс дотроо Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Сэлэнгэ гэх мэт 6 аймаг, улсын нийслэлийн Багануур дүүрэгтэй хаяална. Улаанбаатар хотоос 331км зайд аймгийн төв орших бөгөөд “Мянганы зам”-ын хэвтээ чиглэлийн Багануур- Өндөрхаан, Дорнод аймгийн Чойбалсан, Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотуудыг холбосон дэд бүтэцтэй. Их эзэн Чингис хааны төрж, өссөн нутаг, Монголын их гүрэн байгуулагдсан түүхэн газар бөгөөд Дэлхийн өвд бүртгэлтэй “Бурхан халдун” хайрхантай, 6730 соёлын үл хөдлөх дурсгалуудтай.

**Нийгэм эдийн засгийн** хувьд 72,3 мян хүн амтай, 23,5 мянган өрхтэй, 18 сум, 5 тосгон, 88 багтай, ДНБ-ний 56.4%-г ХАА-н бүтээгдэхүүн эзэлж байна. Чингис хот нь Хэнтий аймгийн хамгийн их хүн амын нягтшилтай газар юм.

**Газарзүйн тогтоцын** хувьд Хэнтий аймаг нь баруун талаараа Хэнтийн нурууны зүүн хошуу сунайна. Нуруунд төрийн тахилгат Бурхан Халдун уул байдаг. Нурууны араас Онон гол, өврөөс аймгийн урд талаар хөндлөн урсдаг Хэрлэн гол эх авдаг байна. Ойт хээр болон тал хээр хосолсон 80,3 мян км<sup>2</sup> газар нутагтай.



# “ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

Тайлбар бичиг

## 1.3 Төслийн техникийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	НЭГЖ	1-Р ЗАМ	2-Р ЗАМ	3-Р ЗАМ	4-Р ЗАМ	5-Р ЗАМ
1	Замын зэрэг	-	III	III	III	III	III
2	Замын урт	км	5.396	0.97	3.701	0.71	0.48
3	Тойруугийн тоо	ш	4	5	7	5	2
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	250	50	250	8	250
5	Тойруугийн хамгийн их радиус	м	3000	1000	1500	100	300
6	Тойруугийн нийт урт	м	1363.8	490.5	1092.8	67.2	88.7
7	Тойруугийн трассд эзлэх хувь	%	25	50.5	29.5	9.4	18.4
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	1500	500	3000	-	-
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	30000	2500	25500	-	-
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	15000	2500	35000	-	5500
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	25000	9500	35000	-	6500
12	Дагуугийн хамгийн их налуу	%	2.3	1.99	1.26	0.55	1.25
13	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	м	60.17	7.77	112.4	77.3	15.8
14	Замын далангийн өргөн	м	11, 14.18	13.68	14.18	14.18	14.18
15	зорчих хэсгийн өргөн	м	7	7	7	6	7
16	Хөвөөний бэхэлгээтэй хэсгийн өргөн	м	0.5x2	-	-	-	-
17	Хөвөөний бэхэлгээгүй хэсгийн өргөн	м	1.5x2	0.5x2	0.5x2	0.5x2	0.5x2
18	Явган хүний замын өргөн	м	1.5, 1.5x2	1.5x2	1.5, 1.5x2	1.5x2	1.5x2
19	Дугуйн зам	м	2.0	-	2.0	-	-
20	Тооцоот хурд	Км/цаг	60	30	60	30	30
21	Өндөрлөгөөний хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5
22	Ухмалын хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5
23	Хучлагын хийц	-	Суурийн доод үе-30см ЦБХ-20см Жижиг ширхэгтэй асфальтбетон -3см Том ширхэгтэй асфальтбетон-4см			Суурийн доод үе-30см ЦБХ-15см Элсэн хайрган үе -5см Зиг заг хавтан – 8см	Суурийн доод үе-30см ЦБХ-20см Жижиг ширхэгтэй асфальтбетон -3см Том ширхэгтэй асфальтбетон-4см

# “ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

Тайлбар бичиг

№	Үзүүлэлтүүд	НЭГЖ	7-Р ЗАМ	6-Р ЗАМ	8-Р ЗАМ	9-Р ЗАМ
1	Замын зэрэг	-	III	III	III	III
2	Замын урт	км	0.148	0.764	1.203	0.517
3	Тойруугийн тоо	ш	-	7	4	8
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	-	6	250	6
5	Тойруугийн хамгийн их радиус	м	-	30	2500	50
6	Тойруугийн нийт урт	м	0	82.9	269.9	75
7	Тойруугийн трассд эзлэх хувь	%	0	10.8	22.4	14.5
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	-	7500	10000	-
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	-	9500	10000	-
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	-	-	10000	15000
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	-	-	10000	15000
12	Дагуугийн хамгийн их налуу	%	0.67	0.7	0.47	0.389
13	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	м	146.6	55.61	241.8	71.17
14	Замын далангийн өргөн	м	12.68	12.68	13.68	12.68
15	зорчих хэсгийн өргөн	м	6	6	7	6
16	Хөвөөний бэхэлгээтэй хэсгийн өргөн	м	-	-	-	-
17	Хөвөөний бэхэлгээгүй хэсгийн өргөн	м	0,5	0,5	0,5	0,5
18	Явган хүний замын өргөн	м	1,5x2	1,5x2	1,5x2	1,5x2
19	Тооцоот хурд	Км/цаг	30	30	30	30
20	Өндөрлөгөөний хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5
21	Ухмалын хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5
22	Хучлагын хийц	-	Суурийн доод үе-30см ЦБХ-20см Жижиг ширхэгтэй асфальтбетон - 3см Том ширхэгтэй асфальтбетон-4см	Төрөл-1 Суурийн доод үе-30см ЦБХ-20см Жижиг ширхэгтэй асфальтбетон -3см Том ширхэгтэй асфальтбетон-4см Төрөл-2 Суурийн доод үе-30см ЦБХ-15см Элсэн хайрган үе -5см Зиг заг хавтан – 8см	Суурийн доод үе-30см ЦБХ-20см Жижиг ширхэгтэй асфальтбетон - 3см Том ширхэгтэй асфальтбетон-4см	



# “ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

*Тайлбар бичиг*

## 1.4 Уур амьсгал

Замын байрлал нь авто замын уур амьсгалын **IIВ** бүсэд хамаарагдана. Төсөллөж буй замын талбайн цаг уурын үзүүлэлтүүдийг АЗУАГН-ээр өгвөл:

- Агаарын жилийн дундаж температур - 2° - +2°
- Газрын гадаргын олон жилийн дундаж температур +0° - +3°
- Агаарын даралт, мм Hg баганын өндрөөр – 600-650
- Жилийн харьцангуй чийгшил – 50-60%
- Цасан бүрхүүлийн тогтох ханзрах хугацаа 17.XI-14.III
- Жилд дунджаар 242мм хур тунадас орох ба дулааны улиралд 231мм байна.

Гаднах агаарын сар, жилийн дундаж температур, °C

Хүснэгт 1.

Станц	Сар												Жил
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Өндөрхаан	-23.5	-19.4	-9.2	2.6	10.8	16.9	19.1	16.9	9.7	0.5	-12.3	-20.6	-0.7

Гадна агаарын үнэмлэхүй хамгийн их температур, °C

Хүснэгт 2.

Станц	Үнэмлэхүй хамгийн их	Он сар өдөр	VII сарын үнэмлэхүй ихийн дундаж
Өндөрхаан	38.9	1937.VIII.10	32.9

Гадна агаарын үнэмлэхүй хамгийн бага температур, °C

Хүснэгт 3.

Станц	Үнэмлэхүй хамгийн бага	Он сар өдөр	I сарын үнэмлэхүй бага дундаж
Өндөрхаан	-46.3	1947.I.20	-37.2

Бүсийн тодорхойлолт

Хүснэгт 4.

Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Уур амьсгалын болон хөрсний нөхцөл
II. Авто замын уур амьсгалын хээрийн бүс	IIВ. Уулын завсар хоорондын тал хээрийн дэд бүс	-Авто замын уур амьсгалын хуурай-хүйтэн сэрүүвтэр хахир, хуурайдуу, сэрүүвтэр хүйтэн бэсрэг уулт хээр, хээр талын хахирлаг дэд бүс.	-Тал хээрийн дэд бүс нь улирлын хөлдөлттэй овойлт болон суулт үүсгэнэ. Цас нимгэн, хахир өвөлтэй. -Газар хөдлөл 6-7 балл.

# “ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

*Тайлбар бичиг*

Авто замын уур амьсгалын бүсүүдийн  
улирлын үргэлжлэх хугацаа

Хүснэгт 5.

Бүс	Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
		Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног
II	IIВ	1-9.XI 5.XI	15-24.III 19.III	126-143 134	6-12.V 9.V	45-52 48	6-19.IX 13.IX	112-156 129	44-54 49

Хөрс агаарын температурын (°C) үзүүлэлт

Хүснэгт 6.

Бүс	Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаарын орчны дундаж температур, °C		
		Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° нэвчих гүн, см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
II	IIВ	+0...+3	60-65	-41...-45	250-350	-2...+2	-20...-25	15...20

Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Хүснэгт 7.

Бүс	Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
		Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
II	IIВ	20-30.X 25.X	15.III-30.IV 5.IV	120-195 160	15.III-10.IV 25.III	15.IV-31.V 23.IV	20-50 35

### *1.5 Авто зам сайжруулах зайлиггүй шаардлага*

Хэнтий аймгийг ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн зорилт-2026 бодлогын баримт бичигт тусгаснаар тогтвортой эдийн засаг, нийгмийн өсөлтийг хангах, экосистемийн тогтвортой байдлыг хадгалан аялал жуулчлал, хөдөө аж ахуй тэргүүлэх салбараа болгож, байгалийн нөөцийг зохистой ашиглах замаар иргэд эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилго, зорилтуудыг дэвшүүлж байна.

Үүний хүрээнд нутгийн иргэдэд түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэдийн эрүүл таатай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, зохистой тээврийг хөгжүүлэхэд аймгийн төвийн авто замыг сэргээн засварлах нь нэн тэргүүнд шаардлагатай байгаа юм.

Түүнчлэн аймгийн Засаг Даргын 2016-2020 мөрийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих “Эрүүл мэнд- Хөдөлгөөн- Хөгжил” хөтөлбөрийн дагуу эрүүл зөв амьдрах дадлыг хэвшүүлэхэд явган алхах, унадаг дугуйгаар явах боломжийг бүрдүүлэн боломжит газруудад унадаг дугуйн болон явган замыг төлөвлөсөн болно. Мөн энэхүү ажлын хүрээнд “Манай гудамж – гэрэлтэй гудамж” мөрийн





1.6 Трассын орчмын судалгаа

Энэ төслийн хүрээнд хийгдэж байгаа 9 хэсэг замууд нь Хэнтий аймгийн ерөнхий төлөвлөгөөнд тугсгагдсан авто замууд бөгөөд Үүнээс 1р зам буюу Их тойруун зам нь ирээдүйд Улсын чанартай АО501 дугаартай замыг орлож Чингис хотын төвөөр орохгүйгээр өнгөрөх гарах тухайлбал Хүнд даацын тээврийн хэрэгслүүд энэ замаар зорчих зорилготой хийгдэж байгаа зам болно.

Шинэ Өндөрхаан тойргийн зам буюу 3р зам нь Чингис хотын алслагдсан хороололыг авто замын сүлжээгээр хангах цаашид барилгажилтыг нэмэгдүүлэх хэтийн харсан авто зам юм. Бусад хэсгүүдийн зам орон сууцны хороололыг төвийн аймгийн зам сүлжээтэй холбогдохоор Хэнтий аймгийн ЗТДГ-д саналаар Авто тээвэр хариуцсан газраас тээврийн хэрэгсэлийн тоо /Зураг 4с үзэх/ тулгуурлан хучилтын хийц уулзваруудыг тооцон төлөвлөсөн. Орон сууцны хороолол дундуур тавигдаж буй замууд дээр хуучин хүүхдийн тоглоомын талбай, авто машины зогсоолын талбайг шинэчлэж шинээр хийгдэхээр зураг төсөлд тусгасан. Инженерийн шугам сүлжээ зам дагууд байрласан хэсэгт шинэчлэх мөн хамгаалах чиглэлээр зураг төслийн зөвшөөрөлтэй байгуулгаар хамгаалах шинэчлэх зураг төслийг хийж гүйцэтгэв.

Зураг.4

2017 оны 11-р сарын 23ны байдлаар Хэнтий аймгийн тээврийн хэрэгслийн тоо

№	сүмд	сүүдлын		ачааны машин	тусгай зориулалт	механизм	чиргүүл	дун	
		мотоцикл	машин						
1	Галшар	19	205	0	247	12	0	8	491
2	Баянхутаг	53	245	0	272	11	0	6	587
3	Баянмөнх	15	143	1	136	8	1	0	304
4	Дархан	65	184	0	180	0	4	7	440
5	Дэлгэрхаан	17	173	0	159	10	1	2	362
6	Жаргалтхаан	48	147	2	163	7	1	4	372
7	Цэнхэрмандал	12	130	1	116	6	0	0	265
8	Өмнөдэлгэр	72	447	0	385	19	0	8	941
9	Батширээт	23	184	0	101	15	0	4	327
10	Биндэр	63	315	1	194	9	1	11	594
11	Баян адарга	15	184	0	164	10	0	3	376
12	Дадал	7	139	1	110	1	4	1	263
13	Норовлин	59	160	0	177	12	2	1	411
14	Батноров	47	400	1	270	3	4	4	729
15	Баян Овоо	37	119	0	129	7	0	1	293
16	Хэрлэн	154	3218	15	1212	99	26	55	4779
17	Мөрөн	30	185	0	178	11	0	2	406
18	Бор өндөр	43	764	10	281	80	5	33	1216
19	Бэрх	25	81	1	106	14	0	4	231
20	Өлзийт	10	81	1	51	1	0	1	145
21	Гурванбаян	17	30	0	26	0	0	0	73
22	Хэрлэн баян үлаан	5	20	0	13	1			39
23	нийт	836	7554	34	4680	336	49	155	13644

судалгаа гаргасан Бүртгэлийн мэргэжилтэн  
Хянсан Хэнтий автотээрийн дарга



## 2. ЗАМЫН ШИНЖ ЧАНАР

### 2.1 Авто замын байр зүйн зураглал

Геодезийн цэг, тэмдэгтийг байгуулахдаа “Геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулах ажил” БД 11-104-06-ыг баримталсан. Шинээр цутгаж бэлтгэсэн геодезийн төв цэгүүдээ газарт бэхэлж суулгах ажлыг бригад зохион байгуулж хийж гүйцэтгэсэн бөгөөд УГЗЗГ-ын даргын 2002 оны 11-р сарын 27-ны өдрийн 55-р тушаалаар батлагдсан загвараар гаднах тэмдэглээсийг гүйцэтгэсэн.

Полигонометрын байрлалын сүлжээнд шинээр суулгасан цэгүүд нь төлөвлөж байгаа замын трассын дагуу хамгийн ихдээ 1.2-1.6 км-г 100 метрийн өргөн зурвас дотор байрлахаар төлөвлөсөн талбайд сонгон авсан.

Уг хувийн хэрэгт цэгийн байрлалыг харуулсан гэрэл зургийг хол, ойр хоёр байдлаар авч оруулсаны дээр цэгийн орчны тойм зураг, зай хэмжээсийн байдал, байршлын тухай мэдээлэл, суулгаж судалсан хүн, хугацаа зэргийг харуулсан.

Зураглалын талбайн ойролцоо байгаа Улсын геодезийн үндсэн сүлжээн дэх WGS-84 системд тодорхойлогдсон Хэрлэн суманд байдаг өндөрийн сүлжээний ГРА-0019 дугаартай, GPS-н сүлжээний ГЦТ-1807 дугаартай үндсэн сүлжээний цэгийг эхлэл болгон ашиглалаа.

Зураглалын ажлыг байрлал өндрийн хувьд UTM солбицлын тогтолцоо WGS-84 эллипсоид, түүний их хагас тэнхлэг 6378137 м, түүний шахцал 1:298.257223563-г ашигласан ба Балтийн тэнгисийн өндөртэй тогтолцоонд гүйцэтгэв.

Тулгуур сүлжээг Хэрлэн сумын GPS-ийн 24 цагийн хэмжилтэй нивелирийн II ангийн цэг болох ГЦТ-1807 цэг дээр тулгуурлан 2 долгионы GPS-ийн RTK горимын Observed Control Point хэмжилтийг Trimble фирмийн R8, R6 маркын Glonasst-тай GPS-ээр тасралтгүй 2 цагаас доошгүй хугацаанд хэмжилт хийсэн болно. Дэлгэрэнгүйг геодезийн тайлангаас үзнэ үү.

### 2.2 Авто замын зурвас талбайн инженер-геологийн нөхцөл ба хөрсний физик - механик шинж чанар

Авто замын трассын дагууд өрөмдсөн 27 цооногоос аллюви-пролювийн гаралтай, бор шаргал, бор саарал, цайвар саарал өнгөтэй, сайргархаг элсэн хөрс, элсэнцэр, шавранцар хөрс илэрсэн бөгөөд дээрх хөрс чулуулаг нь газрын гадаргуугийн хэлбэр дүрсээс хамаарч харилцан адилгүй зузаалагтайгаар өнгөн хөрс, авто замын далангийн доороос илэрсэн бөгөөд дээрхи хөрсийг инженер-геологийн 2 элемент (ИГЭ)-д ангилан үзлээ. Судалгааны талбайд бор хүрэн өнгөтэй, элсэнцэр хөрс бүхий өнгөн хөрс 0.3-0.6 м зузаантайгаар шавранцар, сайргархаг элсэн хөрсийг хучиж тогтсон байна. Сайргархаг элсэн хөрсний дотор шавранцарын мишил үеүд линз хэлбэрээр тохиолдож байна. Судалгааны зурвас талбайд одоо байгаа авто замууд нь эвдрэл, гэмтэл ихтэй болсон байна.



**Геологийн тогтоц.** Судалгааны талбайн хэмжээнд Пермийн вулканоген тунамал хурдас, туфийн төрлийн чулуулгууд Цагаан цавын свитийн /J<sub>3</sub>-K<sub>1cc</sub>/ андезит, базальтаар хучигдсаныг Палеоген-Неогены ангилагдаагүй хурдас хучиж тогтсон. Хэрлэн голын дагуу чиглэлтэй 2 паралель хагарлаар блок маягаар доошоо суусныг стратиграфийн нийцлэгээр дунд дээд орчин үеийн дөрөвдөгчийн хурдас хучиж тогтсон.

Дөрөвдөгчийн настай, аллюви, аллюви-пролювийн хурдас:

а. Дээд орчин үеийн дөрөвдөгчийн аллюви-пролювийн гаралтай хурдас: Хэрлэн голын татмын дээрх I дэнжид хуримтлагдсан сайргархаг элс, сайргархаг шавранцар, элсэн чигжээстэй сайр, сайрга, шавранцар, шавар хөрснүүд үелэн тогтсон. 25.0-30.0 м хүртэл зузаан.

б. Орчин үеийн дөрөвдөгчийн аллювийн хурдас: Хэрлэн голын татмын хэмжээнд сайргархаг элс, шавранцар, элсэнцэр, сайргархаг шавранцарын үеүд ээлжлэн тогтох ба зузаан нь 15.0 м хүрнэ.

**Гидрогеологийн нөхцөл.** Хангай, Хэнтийн атираат мужийн хөрсний ус тархсан район ба уулс хоорондын усны тархалтын мужийн шилжилтийн бүсэд орно.

а. Доод Пермийн вулканоген тунамал чулуулгуудын ан цавын бүсэнд:

Ус агуулагч хурдас чулуулгууд нь: Базальт, андезит-базальт, андезит-порфирит, тэдгээрийн туфүүд болно. Ус агуулагч үе нь ан цавшилт хүчтэй автсан ба аажмаар ан цавын хэмжээ багасч, нягт жижиг кристаллаг тогтоцтой болдог.

б. Орчин үеийн дээд Дөрөвдөгчийн аллюви-пролювийн уст давхарга: Талбайн ихээхэн хэсэгт тархсан. Уст давхаргын зузаан 2.0-5.0 м хүрдэг. Ус агуулагч чулуулгууд нь янз бүрийн хэмжээгээр сайрга агуулсан элс, сайр, сайрга, элсэнцэр, шавранцар тэдгээрийн линзүүд ээлжлэн тохиолдоно. Газрын гадаргуугийн хэмжээнээс хамаарч 2.2-10.0 м хүртэл гүнээс илэрдэг. Ундарга нь харилцан адилгүй, түүнчлэн ус агуулагч литологи, гидрогеологийн онцлогоос хамаарах тул 2.4-3.5 м түвшний бууралттай үед ундарга нь 4.0-9.4 л/с байдаг. Найрлагын хувьд Гидрокарбонат кальц натрийн төрлийн ус зонхилох ба эрдэсжилт нь 0.5-1.0 г/л болно. Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудад хөрсний ус 2.2-3.6 м гүнээс илэрч, 1.8-3.1 м гүнд хөөрч тогтсон байна.

Дэлгэрэнгүй тайланг инженер-геологийн тайлангаас үзнэ үү.



**2.3 Трасс сонголт болон Тухайн орчны одоогийн байдал**

**1. Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвд баригдах 5.396км Их тойруугийн авто зам**

Энэ хэсгийн зам нь А0501 зам буюу улсын чанартай авто замаас салж аймгийн төвийг баруун талаар тойрон гарж Нисэхийн замтай огтлолцож, Хангамжийн замтай нийлж Гандангын зүүн талаар явах замтай огтлолцож төгсөнө. Аймгийн ЗДТГ-с санал болгож өгсөн трассыг үндэслэн авто зам зураг төсөл боловсруулсан. Одоо байгаа замтай хэсэг буюу Уулзвар -1 д хучилтыг суурь болгон ашиглан зарим хэсэг 5см хучихаар төлөвлөсөн. Нисэхийн замтай огтлолцсон хэсэг буюу Уулзвар2-н 0+000 ~ 0+080 хэсэгт одоо байгаа замын цемент бетон хучилтыг хүчитгэж сайжируулна мөн 0+080~ 0+258.7 хүртэлх замыг суурь болгон ашиглаж дээр нь хучилтын хийцийг нэмж хийхээр төлөвлөв. Трассын төгсгөлд буюу Уулзвар-4 орчимд 5см хучихаар тооцсон. Мөн Км3+400 ~ Км4+512.88 хооронд Бор шаргал өнгийн хагас консистенцтэй шавранцар намгархаг хөрс байгаа тул энэ хэсэгт 40см хөрс солилт хийж чулуун дүүргэлт хийж дүүргэнэ.



*Трассын эхлэл. Уулзвар-1 Одоо байгаа замаас зүүн урагш чиглэн аймгийг алуур тойрох*



*Уулзвар-2 Аймгийн төвөөс нисэх онгоцны буудалруу бетон замтай огтлолцож буй хэсэг*



*Уулзвар-3 Хангамжийн замтай огтлолцож буй хэсэг Хангамжын замын трассын эхлэл*



*Трассын эхлэлээс 4.2км орчимд Хэнтий аймгийн гандан тэгчилэн хийд хойгуур*



*Суурьшиллын бүсийн эхлэл*



*Уулзвар-4н трассын эхлэл орчим дахь одоо байгаа автозам*



*Уулзвар-4н трассын төгсгөл орчим дахь одоо байгаа автозам*



*Трассын төгсгөл нь одоо байгаа авто замтай нийлнэ.*





**2. Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвд баригдах Хангамжийн гудамжны 0.97км авто зам**

Энэ хэсгийн зам нь Их тойруун замаас салж Гэр хороололын бүс дундуур нисэх замтай огтлолцсоноор төгсөнө. Аймгийн ЗДТГ-с санал болгож өгсөн трассыг үндэслэн авто зам зураг төсөл боловсруулсан. Уулзвар -2 буюу нисэхийн замтай огтлолцсон хэсэг дээр одоо байгаа авто замыг төлөвлөж буй замын суурь болгон ашиглаж дээр нь хучилтын хийцийг нэмж хийхээр төлөвлөв.



*Трассын эхлэл. Их тойруугийн замтай огтлолцсон хэсэг*



*Трассын дагуу одоо байгаа хөрсөн зам /Автогрейдээрээр хуссан байдал/*



*Трассын эхлэлээс 0,2км орчимд автомашины зогсоол төлөвлөх талбай*



*Трассын төгсгөл нисэхийн замтай огтлолцоно*



**3. Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвд баригдах Шинэ Өндөрхааны тойргийн 3.701км авто зам**

Энэ хэсгийн зам нь А0501 зам буюу улсын чанартай авто зам дээр байрлаж буй МТ клонкоос хойш 30 гаруй метрээс салж аймгийн төвийн хойд талаар алслагдсан суурьшилын бүсийг төвийн замуудтай холбох Аймгийн ЗДТГ-с санал болгож өгсөн трассыг үндэслэн авто зам зураг төсөл боловсруулсан. Уулзвар-1 хэсэгт одоо байгаа замыг 5см хучихаар төлөвлөв. Уулзвар 2 нь Булагийн гудамжтай, Уулзвар-3 нь Баянмөнхийн гудамжтай холбогдохоор энэ хэсгүүдийг төлөвлөсөн.



*Трассын эхлэл. МТ клонкоос хойш 40орчим метрд*



*Уулзвар-2 трассын төгсгөл Булагийн гудамжтай нийлнэ*



*Уулзвар-3 трассын төгсгөл Баянмөнхийн гудамжтай нийлнэ*



*Трассын төгсгөлд уулзвар төлөвлөсөн*



**4. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3 дугаар баг С-29, С-80, С-78 дугаар байрны урдуур үргэлжлэх 0.71 км авто зам**

Энэ хэсэгт Орон сууцны хороолол доторх зам бөгөөд инженерийн шугам сүлжээ замын дагууд байрлаж байна. Иймээс энэ хэсгийн замын хучилтын хийцийг Зиг заг хавтан байхаар төлөвлөв. Хүүхдийн тоглоом талбай болон Авто машины зогсоолын талбайг хийж өгөхөөр төлөвлөсөн. Хуучин замын хучилтыг хуулж зиг заг хучилтыг нийт энэ хэсгийн замд хийнэ.



*Трассын эхлэл инженерийн шугам шугам сүлжээ трассд орсон ба зиг заг хучилттай*



*Хүүхдийн тоглоомын талбай*



*1р хэсэг орчимын замын одоогийн байдал*



*Энэ хэсэгт хүүхдийн тоглоомын талбай болон авто машины зогсоол төлөвлөнө*



*2р хэсэг замын трасс, автомашины зогсоол төлөвлөх талбай /0+000~0+080орчим/*



*2р хэсэг замын трасс, автомашины зогсоол төлөвлөх талбай /0+100~0+220орчим/*





**5. Хэнтий аймгийн Хэрлэн сумын төв баригдах Холбооны гудамжны 0.48км авто зам**

Аймгийн ЗДТГ-с санал болгож өгсөн трассыг үндэслэн авто зам зураг төсөл боловсруулсан. Холбооны гудамжны урд хэсэгт зогсоолын талбай төлөвлөсөн айлуулруу орц гарц тухай бүрд нь гаргаж өгсөн. Хуучин одоо байгаа хучилтыг хуулж шинээр 5см хучилт хийж өгөхөөр төсөвд оруулсан.



*Трассын эхлэл*



*Автомашинны зогсоолын талбай төлөвлөнө  
0+040 ~ 0+100 орчимд*



*Одоо байгаа авто машины зогсоол*



*Трассд орсон зайлуулагдах хуучин байшингын  
бетон суурь*



*Трассд орсон зайлуулагдах бетон шонгууд*



*Замын трассын төгсгөл 4 замын уулзвар  
төлөвлөнө*



**6. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4-р багийн хорооллын доторх 0.764км авто зам**

Энэ хэсэгт Орон сууцны хороолол доторх зам бөгөөд инженерийн шугам сүлжээ 1р хэсгийн замын дагууд байрлаж байна. Иймээс 1р хэсгийн замын хучилтын хийцийг Зиг заг хавтан байхаар төлөвлөв. Хүүхдийн тоглоом талбай болон Авто машины зогсоолын талбайг хийж өгөхөөр төлөвлөсөн.



*1р хэсэг трассын эхлэл автомашины зогсоолын талбай төлөвлөв /зиг заг хучилттай/*



*1р хэсгийн трассын төгсгөл авто машины зогсоолын талбай төлөвлөв*



*2р хэсэг хүүхдийн тоглоомын талбай болон авто машины зогсоолын талбай төлөвлөв*



*2р хэсэг Шинээр төлөвлөгдөх авто машины зогсоол*



*3р хэсгийн трассын эхлэл орчим*



*3р хэсэг хүүхдийн тоглоомын талбай болон авто машины зогсоолын талбай төлөвлөв*



**7. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3-р баг А-28 дугаар байрны урд талын 0.148км авто зам**

Энэ хэсэг 1р сургуулийн зүүн хойноос Орон сууцны хороололын дундуур явж одоо байгаа авто замтай холбогдоно. Орон сууцны урд авто машины зогсоолын талбайг хийж өгөхөөр төлөвлөсөн.



*Трассын эхлэл. орон сууцны урд зогсоолын талбай төлөвлөнө*



*Трассд орсон зайлуулагдах бетон*



*Орон сууцны урд зогсоолын талбай төлөвлөв*



*Трассын төгсгөл*

**8. Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвд баригдах Эрчмийн гудамжны 1.203км авто зам**

Энэ хэсэг нь Үйлдвэрчидийн гудамжийг Тариаланчидын гудамжтай холбосон авто зам юм. 1р хэсгийн авто замын дагууд инженерийн шугам сүлжээ байрлаж байгаа тул бид 0+026 ~ 0+430 хооронд зиг заг хучилт төлөвлөж өгсөн. 1р хэсэгт 2 байрлалд автобусны буудал төлөвлөв.





2р хэсэг болон 3р хэсгийн зам нь Тэмүжингийн гудамжтай холбогдох зам юм. Авто замаар хөндлөн гар инженер шугам огтлолцож буй хэсэгт зиг заг хучилт тухай бүрд нь хэсэгчилж хийнэ.



*Трассын эхлэл автобусны буудлын хойноос эхлэнэ. Буудлыг шилжүүлнэ./1р хэсэг/*



*Трассд орсон инженерийн шугам сүлжээ энэ хэсэгт зиг заг хавтангаар хучилт хийнэ /0+026~0+420 хүртэл/*



*Трассд орсон блокон хашааг буулгана*



*Трассын төгсгөлд трассд орсон блокон хашааг буулгана /1р хэсэг/*



*2р хэсгийн трассын эхлэл орчим*



*2р хэсгийн трассын төгсгөл орчим*



*Зр хэсгийн трассын эхлэл орчим*



*Зр хэсгийн трассын төгсгөл орчим*

**9. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5-р баг Сангийн аж ахуйн орон сууцны доторх 0.517км авто зам**

Энэ хэсэгт Орон сууцны хороолол доторх зам бөгөөд инженерийн шугам сүлжээ замын дагууд байрлаж байна. Иймээс энэ хэсгийн замын хучилтын хийцийг Зиг заг хавтан байхаар төлөвлөв. Орон сууцны хороололд Хүүхдийн тоглоом талбай болон Авто машины зогсоолын талбайг хийж өгөхөөр төлөвлөсөн. Мөн Сургууль болон цэцэрлэг орчимд одоо байгаа зогсоолын талбайг сайжируулж шинэчлэж хийхээр төлөвлөв.



*Трассын эхлэл. Сангийн аж ахуйн орон сууцруу орсон замын гарц*



*Хүүхдийн тоглоомын талбай, автомашины зогсоолын талбай төлөвлөв.*



*Орон сууцны урд зогсоолын талбай, хүүхдийн тоглоомын талбай төлөвлөв*



*Сургууль орчим дахь энэ хэсгийн автомашины зогсоолын талбайг шинэчлэж төлөвлөв*



*Цэцэрлэг орчим дахь энэ хэсэгт автомашины зогсоолын талбай төлөвлөв*



*Трассын төгсгөл орчимд*





**2.4 Авто замын төлөвлөлт**

Замын дэвсгэр зургийг М1:500 масштабтайгаар төлөвлөж, замын трасст орсон объектуудыг өнгөөр ялгаж үзүүлэв. Шаардлагатай газруудад орц гарц, авто зогсоол, автобусны буудал болон явган хүний гарцыг төлөвлөсөн. Мөн шаардлагатай газруудад ус зайлуулах байгууламж, уулзвар хэсэг дээр аюулгүй байдлыг бодолцон хайс хийхээр төлөвлөлөө.

**2.5 Техникийн үндсэн үзүүлэлт**

Тус авто замуудын хот доторх авто зам нь Монгол улсад мөрдөгдөж байгаа БНБД 30-01-04 “ХОТ, ТОСГОНЫ ТӨЛӨВЛӨЛТ БАРИЛГАЖИЛТЫН НОРМ БА ДҮРЭМ”-ийн Хүснэгт 10-н дагуу **Орон сууцны хорооллын гудамж зам-д хамрагдаж байна.** Уг нормын дагуу авто замын геометр хэмжээсийг дараах байдлаар төлөвлөлөө.

Хүснэгт 8.

Техникийн үзүүлэлт	Төлөвлөсөн хэмжээ
Тооцоот хурд, км/цаг	30-50
Замын нэг зурвасын өргөн, м	3.0
Замын зурвасын эгнээний тоо	2-3
Тойруугийн хамгийн бага радиус, м	90
Явган замын өргөн	1.5

Харин Их тойруугийн авто зам нь ЗЗБНБД 22-004-2016-н дагуу зэрэглэл 2А, Хуримтлуулагч замд хамаарч байна.

Авто замын төсөллөлтийн үндсэн элементүүдэд тавигдах шаардлага

Хүснэгт 9.

Үзүүлэлт	Зөвшөөрөгдөх хэмжээ
Тооцоот хурд	60 – 80км/ц
Хэвтээ мургуйн хамгийн бага радиус	60км/ц хурдтай үед 1200м
Эргэцтэй хэвтээ мургуйн хамгийн бага радиус	60км/ц хурдтай үед 130м
Эргэц дээрх хөндлөн хэвгийн хэмжээ	40-60%
Дагуу налуун хамгийн бага хэмжээ:	
Гүдгэр босоо муруйн дээрх үзэгдэлт	420м
Хотгор босоо муруйн дээрх үзэгдэлт	85м

**Хөндлөн төлөвлөлтөнд тавигдах шаардлага**

Хүснэгт 10.

**Замын хөндлөн төлөвлөлтийн үзүүлэлт**

Замын ангилал	Хөдөлгөөний зурвасын өргөн, м	Хөвөөний жишиг өргөн, м
Хуримтлуулагч зам Зэрэглэл -2А	3.0 -3.6	1.0 – 2.0

Эх сурвалж: ЗЗБНБД 22-004-2016

Уг стандарт нормын дагуу “Их тойруугийн авто зам” – ыг дараах хоёр янзаар төлөвлөлөө. Учир нь захиалагчийн саналын дагуу гэр хороолол орчимд явган хүний зам мөн унадаг дугуйн замыг төлөвлөсөн болно.

Хүснэгт 11.

а) Төслийн замын санал болгож буй өргөн

№	Хөндлөн төлөвлөлтийн элемент	Тоон утга
1	Нэг зурвасын өргөн, м	3.5м
2	Зурвасын тоо	2
3	Зорчих хэсгийн өргөн, м	7.0м
4	Хөвөөнийн өргөн, м	1.5м
5	Нийт замын өргөн, м	10.0м

б) Төслийн замын санал болгож буй өргөн

Хүснэгт 12.

№	Хөндлөн төлөвлөлтийн элемент	Тоон утга
1	Нэг зурвасын өргөн, м	3.5м
2	Зурвасын тоо	2
3	Зорчих хэсгийн өргөн, м	7.0м
4	Хөвөөнийн өргөн, м	0.5м
5	Унадаг дугуйн замын өргөн, м	2.0м
6	Явган хүний замын өргөн, м	1.5м
	Ногоон байгууламж, м	1.0м

# “ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

Тайлбар бичиг

## 2.6 Уулзвар, Гарц төлөвлөлт

Төлөвлөж буй 9 хэсэг замд нийт 22 уулзвар , 52 гарц төлөвлөв. Уулзвар, гарцын байрлал чиглэлийг хүснэгт 13,14д үзүүлэв.

Хүснэгт13.

Уулзварын Дугаар, №	Байрлал	Чиглэл	Тайлбар
<b>1р зам Их тойруу зам</b>			
1	0+000	Тойрог уулзвар	Мөрөн сум, Чингис хотын төв
2	2+288	4зам	Нисэх, Чингис хотын төв
3	3+660	Зүүн	Хангамжийн зам
4	4+490	4зам	Их тойруу
5	0+000	Баруун, Зүүн	Гандан, Их тойруу(Уулзвар4)
<b>2р зам Хангамжийн гудамжны зам</b>			
1	0+710	Баруун	Гудамж гэр хороолол
2	0+764.3210	Баруун, Зүүн	Нисэх, Чингис хотын төв
<b>3р зам Шинэ Өндөрхааны тойргийн зам</b>			
1	0+000	Баруун, Зүүн	Мөрөн сум, Чингис хотын төв
2	0+880	4зам	Шинэ Өндөрхаан хороолол, Булаг
3	1+510	4зам	Шинэ Өндөрхаан хороолол, Баянмөнх
4	2+470	4зам	Шинэ Өндөрхаан хороолол, Саригийн гудамж
<b>5р зам Холбооны гудамж зам</b>			
1	0+000	Баруун,Зүүн	Тэмүжингийн гудамж
2	0+270	4зам	Сэцэнханы гудамж, Хэрлэнгийн гудамж
3	0+000	4зам	Сэцэнханы гудамж, Хүүхэд багачуудын гудамж
<b>6р зам 4багын хороолол дундах зам</b>			
1	0+000	Баруун,Зүүн	Тэмүжингийн гудамж
<b>8р зам Эрчимийн гудамж зам</b>			
1	0+000	Баруун,Зүүн	Үйлдвэрлэгчидийн гудамж
2	0+300	Баруун	Хаус хороолол
3	0+400	Баруун	Хаус хороолол
4	0+708	Баруун,Зүүн	Тариаланчдын гудамж
5	0+000’	Баруун,Зүүн	Тэмүжингийн гудамж
6	0+000’’	Баруун,Зүүн	Тэмүжингийн гудамж
<b>9р зам Сангын аж ахуйн зам</b>			
1	0+000	4зам	Тариаланчидын гудамж



# “ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

Тайлбар бичиг

Хүснэгт14.

Уулзварын Дугаар, №	Байрлал	Чиглэл	Тайлбар
<b>1р зам Их тойруу зам</b>			
1	0+927,4	Баруун, Зүүн	Хот айл, Чингис хотын төв
2	1+825,4	Баруун, Зүүн	Хот айл, Чингис хотын төв
3	2+480	Зүүн	Гудамж гэр хороолол
4	3+140	Баруун, Зүүн	Хэрлэн гол ,Гудамж гэр хороолол
5	3+367,6	Зүүн	Гудамж гэр хороолол
6	3+884	Зүүн	Гудамж гэр хороолол
7	4+120	Баруун, Зүүн	Гандан ,Гудамж гэр хороолол
8	4+220	Зүүн	Гудамж гэр хороолол
<b>2р зам Хангамжийн гудамжны зам</b>			
1	0+100	Баруун, Зүүн	Гудамж гэр хороолол
2	0+142	Баруун	Гудамж гэр хороолол
3	0+195.7	Баруун	Гудамж гэр хороолол
4	0+315.8	Баруун	Гудамж гэр хороолол
5	0+386.1	Зүүн	Гудамж гэр хороолол
6	0+426.8	Баруун	Гудамж гэр хороолол
7	0+560	Зүүн	Гудамж гэр хороолол
8	0+640	Зүүн	Гудамж гэр хороолол
<b>3р зам Шинэ Өндөрхааны тойргийн зам</b>			
1	0+130	Баруун, Зүүн	МТ клонк, Хот айл
2	0+300	Баруун	Гудамж гэр хороолол
3	0+480	Баруун, Зүүн	Гудамж гэр хороолол
4	0+730	Баруун, Зүүн	Гудамж гэр хороолол
5	1+040	Баруун, Зүүн	Гудамж гэр хороолол
6	1+340	Зүүн	Гудамж гэр хороолол
7	1+640	Баруун, Зүүн	Гудамж гэр хороолол
8	1+690	Зүүн	Гудамж гэр хороолол
9	2+100	Баруун	Гудамж гэр хороолол
10	2+170	Зүүн	Гудамж гэр хороолол
<b>4р зам</b>			
1	0+000	Баруун зүүн	Титэм, Төв зам (2 хэсэг)
2	0+088	Баруун зүүн	Орон сууц хороолол, Төв зам (2 хэсэг)

# “ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

Тайлбар бичиг

3	0+158	Зүүн	Орон сууц хороолол (2 хэсэг)
4	0+226	Баруун зүүн	Орон сууц хороолол, Төв зам (2 хэсэг)
5	0+228.1	Баруун зүүн	Орон сууц хороолол, Төв зам (1 хэсэг)
<b>5р зам Холбооны гудамж зам</b>			
1	0+017	Баруун	Монгол банк
2	0+116	Баруун	Гудамж гэр хороолол
3	0+157	Зүүн	Айл
4	0+217	Зүүн	Гудамж гэр хороолол
5	0+088	Баруун зүүн	Айл
<b>6р зам 4багын хороолол дундах зам</b>			
1	0+000	Баруун,Зүүн	Боловсролын гудамж (2р хэсэг)
2	0+291.6		Боловсролын гудамж (2р хэсэг)
3	0+130	Баруун	Боловсролын гудамж (3р хэсэг)
<b>7р зам</b>			
1	0+146		Эрүүл энхийн гудамж
<b>8р зам Эрчимийн гудамж зам</b>			
1	0+108	Зүүн	гэр хороолол
2	0+210	Баруун,Зүүн	Гудамж гэр хороолол
3	0+395	Зүүн	Гудамж гэр хороолол
4	0+480	Зүүн	Орон сууц хороолол
5	0+498	Баруун	Гудамж гэр хороолол
6	0+637	Зүүн	Гудамж гэр хороолол
<b>9р зам Сангын аж ахуйн зам</b>			
1	0+030	Зүүн	Орон сууц, Цэцэрлэг
2	0+060	Баруун	Орон сууц
3	0+157	Баруун	Орон сууц
4	0+218	Баруун	Орон сууц
5	0+278	Баруун	Орон сууц
6	0+313		Тариаланчдын гудамж



### 2.7 Хучилтын хийц, тооцоо

Авто замуудын хучилтын хийцийг төлөвлөхдөө хоёр янзын хувилбараар төлөвлөсөн. Үүнд:

- Асфальтбетон хучилт
- Зиг заг хавтан бүхий хучилт


#### Зиг заг хавтан

Захиалагч байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр инженерийн шугам сүлжээ ихтэй газар, шугам сүлжээг шилжүүлэн зөөх боломжгүй тохиолдолд дахин засварлахад тохиромжтой гэж үзэн уг замыг төлөвлөлөө. Зиг заг хавтан нь өөр хоорондоо түгжигдэхээр хэлбэртэй байх бөгөөд дараах төрлийн хийцүүдтэй байна.



Бүх талаараа хоорондоо түгжигддэг. /225mm x112.5mm/

Нэгээс бусад талаараа хоорондоо түгжигддэг./225mm x112.5mm/



Бүх талаараа хоорондоо түгжигддэг /112.5mm x112.5mm/

Зураг 5. Зиг заг хавтан

Үүнээс гадна өөр хоёр хучилтын хийцийг сонгон харьцуулалт хийснийг дараах хүснэгтээс харна уу. Байгалийн чулуун хучилт өртөг өндөр бөгөөд захилагчийн зүгээс «- Тав тухгүй байдаг» гэсэн саналтай байсан. Мөн 20x20 чулуун хучилт нь тав тухтай, материалын нөөц сайн боловч өртөг өндөр байна.






ХУЧИЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ			
Хувилбар	1	2	3
Хучилтын төрөл	Байгалийн чулуун хучилт 	Зиг заг хавтант хучилт 	20x20н чулуун хавтант хучилт 
Зорчигчийн тав тух	Муу	Сайн	Сайн
Хучилтын ажил хийгдэх хугацаа	Их	Богино	Богино
Өртөг, үнэ /1м3/	Үнэтэй	Хямд	Үнэтэй
Засвар арчлалтын зардал	Үнэтэй	Хямд	Хямд
Материалын нөөц	Муу	Сайн	Сайн
Ашиглалтын жил	Удаан	Удаан	Богино
Бат бэх, даац	Сайн	Сайн	Муу
Сонгосон хувилбар	-	+	-

Зиг заг хавтант хучилтыг дараах хэсгүүдэд хийхээр төлөвлөсөн.

- 4-р зам буюу Хэрлэн сумын 3 дугаар баг С-29, С-80, С-78 дугаар байрны урдуур үргэлжлэх 0.71 км авто зам зогсоол
- 6-р зам буюу Хэрлэн сумын 4-р багийн хорооллын доторх 0.764км авто зам
- 8-р зам буюу Хэрлэн сумын төвд баригдах Эрчмийн гудамжны 1.203км авто зам
- 9-р зам буюу Хэрлэн сумын 5-р баг Сангийн аж ахуйн орон сууцны доторх 0.517км авто зам.



Хучилтын хийц:



Зиг заг хавтан 8см

Элс хайрган хольц 5см

Цементээр бэхжүүлсэн суурь 15см

Суурийн доод үе 30см

**Асфальтбетон хучилт:**

- Хучилтын тооцооны аргачлал

Хучилтын тооцооны онол аргачлал нь , практикийн, статистикийн зэрэг олон аргууд байдаг ба дараах аргуудыг түгээмэл ашигладаг.

Асфальтбетон хучилт
1) TA арга
2) AASHTO INTERIM GUIDE METHOD(1972)
3) AASHTO шинэчилсэн (1986)

Дээрх аргуудаас AASHTO INTERIM GUIDE METHOD нь онол болон практикийн үндэслэл ихтэй хучилтын тооцоог хийхэд энгийн хялбар, түгээмэл хэрэглэж ирсэн. 1986 онд INTERIM GUIDE–ийн хучилтын тооцоон элемент нэмэгдсэн ба шинэчлэгдсэн хувилбар нь ашиглагдаж байгаа бөгөөд хучилтын тооцоог бодвол магадлал өндөртэй, шинжилгээ судалгаа сайн системтэй зураг төслийн стандарт юм. AASHTO–ийн шинэчилсэн хучилтын тооцоон стандарт нь далангийн ачааллыг эсэргүүцэх хүчийг(MR) тооцоолох туршилт дутмаг, туршилтын материалууд, оновчтой зураг төслийн төлөвлөлт зэрэг бэрхшээлүүд их учраас уг ажилд INTERIM GUIDE –ээс тохирсон аргыг ашиглах болно.

- Хучилтын зузааны тооцоо

а. Хэтийн хөдөлгөөний эрчим болон нэг тэнхлэг дээрх ачааллын тооцоо

1) Агуулга

- Тус төслийн замын техникийн шаардлагад асфальтбетон хучилтын давхрагыг 3см, 4см-г хувааж нийт 7см-г тооцоолж суурийг 20см, дэд суурийг 30см-ээр тооцоолон хучилтын тэсвэрлэх чадварыг хөдөлгөөний эрчим хамгийн их байхаар төлөвлөсөн.



- AASHTO тооцооллоор Picktime хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг судалж, нэг урсгал дээрх хөдөлгөөний нэвтрүүлэлтийг жил тус бүрийн хөдөлгөөний нэвтрүүлэх чавдартай харьцуулан тооцоолж хүн амын өсөлт, хэтийн төлөв зэргийг ойролцоогоор тооцоолон урт хугацааны хөдөлгөөн нэвтрүүлэх чадварыг төлөвлөн хучилтын зузааныг тооцож, тус төслийн техникийн шаардлагад нийцүүлэн хамгийн их хөдөлгөөн нэвтрүүлэлтэнд тэсвэрлэлт сайтайгаар төлөвлөсөн билээ.
- Замын хөдөлгөөн нь Монгол улсын нутагт 20 жилийн дараа буюу хүн амын өсөлтийг 5,3%-иар өсгөж, хүн амын орлого өссөнөөр авто техникийн тоо хэмжээг 11%-иар өснө гэж тооцоолон төлөвлөсөн билээ.

1) Барилгын ажлын хугацаа, ашиглалтанд өгөх жил, хэтийн жил

Хүснэгт 15.

Ангилал	Барилгын ажлын хугацаа (үндсэн шугам ашиглалтанд орох)	Ашиглалтанд өгөх жил	Хэтийн жил (20 жилийн дараа)
Жил	1	2018	2038

2) Нэг урсгал дээрх хөдөлгөөний эрчим

- Нэг урсгал дээрх хөдөлгөөний эрчмийн тооцоог дараах байдлаар тооцоолсон.

$$W18 = DD \times DL \times W181$$

Үүнд :

W18 - нэг урсгал дээрх хөдөлгөөний эрчим

DD - чиглэлийн хувиарлалтын коэффициент (гол чиглэлийн DD = 0.5)

DL - зорчих хэсгийн хувиарлалтын коэффициент (DL = 1.0)

W181- нийт хөдөлгөөний эрчим

Нэг урсгал дээрх хөдөлгөөний эрчмийн жил тус бүрийг дараах байдлаар төлөвлөсөн ба хэтийн 20 жилийн хөдөлгөөний эрчмийг хучилтын зузааны тооцоонд авлаа.





Хэтийн жилээр нэг зорчих хэсэг дээрх хөдөлгөөний эрчим

Хүснэгт 16.

жил	18Kips ESAL (x106)		Тайлбар
2018	$0.057 \times 0.5 \times 1.0 =$	0.028	Ашиглалтанд өгөх
2028	$0.584 \times 0.5 \times 1.0 =$	0.292	Ашиглалтанд өгсөнөөс хойш 10 жил
2033	$0.890 \times 0.5 \times 1.0 =$	0.445	Ашиглалтанд өгсөнөөс хойш 15 жил
2038	$1.203 \times 0.5 \times 1.0 =$	0.601	Ашиглалтанд өгсөнөөс хойш 20 жил

Хэтийн хөдөлгөөний эрчмийн таамаг: Хучилтын тэсвэрлэж чадах зорчих хэсгийн нэвтрүүлэлт (AADT)

Хүснэгт 17.

Жил	Суудлын авто машин	Автобус		Ачааны машин			Бүгд	Тайлбар
		Бага оврын	Том оврын	Бага оврын	Дунд оврын	Том оврын		
2018	8,310	187	28	929	122	24	9,600	Ашиглалтанд өгөх
2028	9,163	209	30	939	128	26	10,495	Ашиглалтанд өгсөнөөс хойш 10 жил
2033	9,293	211	30	952	131	27	10,644	Ашиглалтанд өгсөнөөс хойш 15 жил
2038	9,353	212	31	958	131	28	10,713	Ашиглалтанд өгсөнөөс хойш 20 жил



Нэг тэнхлэг дээрх ачааллыг шилжүүлсэн хөдөлгөөний эрчим (18Kips)

Хүснэгт 18.

Жил	Суудлын авто машин	Автобус		Ачааны машин			Нийт	Жилд нэг тэнхлэг дээр ирэх хөдөлгөөний эрчим	Нэмэгдсэн байдлаар нэг тэнхлэг дээр ирэх хөдөлгөөний эрчим	Зураг төслийн тооцоот хөдөлгөөний эрчим	Тайлбар
		Бага оврын	Ердийн	Бага оврын	Дунд оврын	Том оврын					
		18Kx365	18Kx106	18Kx106							
2018	2	0	21	1	73	57	155	0.057	0.057	0.028	Ашиглалтанд өгөх
2028	2	0	23	1	77	62	165	0.060	0.884	0.292	Ашиглалтанд өгсөнөөс хойш 10 жил
2033	2	0	23	1	79	65	170	0.062	0.890	0.445	Ашиглалтанд өгсөнөөс хойш 15 жил
2038	2	0	24	1	79	67	173	0.063	1.203	0.601	Ашиглалтанд өгсөнөөс хойш 20 жил

б. CBR болон далангийн .... коэффициент

1) Хучилтын тооцооны стандарт

- Далан: CBR > 10%

Дэд суурийн үе: CBR > 45%

- Суурийн үе: CBR > 80

2) Далангийн газар хөдлөлтийн коэффициент ( Soil Support Vale)

Далангийн газар хөдлөлтийн коэффициентийг AASHTO Interim Guide –д үзүүлсэн аргаар CBR-ийн өгөгдөл болон далангийн газар хөдлөлтийн коэффициентын хамаарлыг нэгтгэсний дараах тооцооноос шалтгаална.

- Далан CBR хамгийн багадаа 15%

- Дэд суурийн CBR хамгийн багадаа 45%



Ангилал	Зураг төслийн CBR	Газар хөдлөлтийн коэффициент (S)	Тайлбар
Далан	15.0	5.77	3.8 x LOG15.0 + 1.3
Дэд суурь (буталсан чулуу)	45.0	7.58	3.8 x LOG45.0 + 1.3

в. Хучилтын үе бат бэхийн коэффициент

Хучилтын үе Ангилал	Асфальт бетон үе	Суурийн үе		Дэд суурийн үе	Тайлбар
		Асфальтын ачааллыг хүлээн авах хязгаар	Цементээр бэхжүүлсэн суурь		
Техникийн шаардлагад заасан бат бэхийн чанар	нягтрал Ø19mm ачааллыг хүлээн авах хязгаар 750 kg дээш	Ачааллыг хүлээн авах хязгаар 350 kg дээш	C.B.R 80-с дээш	C.B.R 45-с дээш	
Бат бэхийн коэффициент	0.157	0.110	0.056	0.048	

г. SN нь хучилтын үе бүрийн зузаан болон бүрдүүлэгч материалын харилцан хамаарлаас гарсан индекс ба замыг нийтийн хэрэглээ болгох индекс нь 2.5 –аас доош болж буурах үед тэнхлэгийн ачаалал болон хучилтын зузааны индексийн хамаарлаар илэрхийлэгддэг. S-д өгөгдөх хэмжээ, бүсийн индекс болон шилжүүлсэн хөдөлгөөний эрчмээс хамаарч хучилтын үе бүрийн хэрэглээний SN өгөгдөлийн гаргалгаа нь дараах байдлаар гарна.

1) Зураг төслийн үндсэн тэгшитгэл (AASHTO)

$$\log(W_{8.2}) = 9.36 \times \log_{10}(SN+1) - 0.20 + \frac{Gt}{0.4 + \frac{1094}{(SN+1)^{5.19}}} + \log_{10}\left(\frac{1}{Rf}\right) + 0.372(SSV - 3.0)$$

эндээс, W8.2 : 8.2t нэг тэнхлэг дээр ирэх ачааллыг нэмсэн хөдөлгөөний эрчим





SN- хучилтын зузааны индекс

Rf- бүсийн индекс (өндөр 500м –ээс дээш бүсэд : 2.5)

Pf- эцсийн зураг төслийн индекс (2.5 )

SSV- далангийн газар хөдлөлтийг тэсвэрлэх хүч ( далан = 5.77, дэд суурийн үе = 7.58)

$$G_t: \text{Log} \left( \frac{4.2 - P_t}{4.2 - 1.5} \right) = -0.20$$

2) Хэрэглээ жилээр (SN) тооцсон

Хүснэгт 21.

Жил	Хэтийн хөдөлгөөний эрчим (x106)	хэрэглээ SN		Тайлбар
		өнгөн үе + суурийн үе	өнгөн үе + суурийн үе + дэд суурийн үе	
2028	0.884	1.96	2.84	Ашиглалтанд өгсөн 10 жил
2038	1.203	2.21	2.86	Ашиглалтанд өгсөн 20 жил

Бат бэхийн коэффициент

- асфальтбетон: 0.157

- суурийн үе: 0.056

- дэд суурийн үе: 0.048

10 жилээр гаргасан хэрэглээ (2028 он)

Хүснэгт 22.

Хучилтын үе	Бат бэхийн коэффициент	Үеийн зузаан (cm)	Хэрэглээ SN	Тооцоолсон үндэслэл		Зураг төсөл SN
Өнгөн үе	0.157	7			7.00cm	0.157x7=1.11
Суурийн үе	0.056	20		(1.96-1.11) / 0.056 =	15.2cm	0.056x20=1.12
Нийт			1.96	T=20 cm судалгааны дүн :	OK	2.23
Дэд суурийн үе	0.048	30		(2.84-1.11-1.12) / 0.048 =	12.7cm	0.048x30=1.44
Нийт			2.84	T=30 cm судалгааны дүн :	OK	3.67



20 жилээр гаргасан хэрэглээ (2038 он)

Хүснэгт 23.

Хучилтын үе	Бат бэхийн коэффициент	Үеийн зузаан (см)	Хэрэглээ SN	Тооцоолсон үндэслэл	Тооцоолсон үндэслэл	Зураг төсөл SN
Өнгөн үе	0.157	7			7.00cm	0.157x7=1.11
Суурийн үе	0.056	20		(2.21-1.11)/0.056 =	19.6cm	0.056x20=1.12
Нийт			2.21	T=20cm судалгааны дүн :	OK	2.23
Дэд Суурийн үе	0.048	30		(2.86-1.11-1.12)/0.048 =	13.1cm	0.048x30=1.44
Нийт			2.86	T=30cm судалгааны дүн :	OK	3.67

Бат бэхийн коэффициент

- асфальтбетон ачааллыг хүлээн авах суурийн үе: 0.110

Хэрэглээний судалгаа

10 жилээр гаргасан хэрэглээ (2028 он)

Хүснэгт 24.

Хучилтын үе	Бат бэхийн коэффициент	Үеийн зузаан (см)	Хэрэглээ SN	Зураг төслийн үндэслэл	Тооцоолсон үндэслэл	Зураг төсөл SN
Өнгөн үе	0.157	7			7.00cm	0.157x7=1.11
Суурийн үе	0.110	20		(1.87-1.11) /0.110 =	6.9cm	0.110x20=2.20
Нийт			1.87	T=20cm судалгааны дүн :	NG	3.31

# “ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

Тайлбар бичиг

20 жилээр гаргасан хэрэглээ (2038 он)

Хүснэгт 25.

Хучилтын үе	Бат бэхийн коэффициент	Үеийн зузаан (см)	Хэрэглээ SN	Зураг төслийн үндэслэл	Зураг төсөл SN
Өнгөн үе	0.157	7		7.00cm	$0.157 \times 7 = 1.11$
Суурийн үе	0.110	20		$(2.1 - 1.11) / 0.110 = 9.0\text{cm}$	$0.110 \times 20 = 2.20$
Нийт			2.1	T=20cm судалгааны дүн :	NG 3.31

### 3) Хучилтын шийдэл

Ашиглах хугацаа 20 жилээр хөдөлгөөний эрчмийн нэвтрүүлэлтийг тооцон хөдөлгөөний ачааллыг даах хучилтын зузааныг 57см гэж судалгаагаар тогтоосон ба 1 - р хувилбар нь техник эдийн засгийн хувьд үр ашигтай, бат бэх гэж үзэн авто замын төлөвлөлтөнд сонгосон.

*Хучилтын хийц:*


Асфальтбетон	7cm	57cm
Цементээр бэхжүүлсэн суурь	20cm	
Суурийн доод үе	30cm	



## 2. 7 Явган хүний замын хийц


Явган хүний замыг бсм-н зузаантай 10см х 20см харьцаатай /В-22.5/ хүрэн, улаан хүрэн, цайвар шар өнгийн өнгөт хавтангуудаар өрж хийнэ. Өрөлтийг зураг төсөлд заасны дагуу зөвлөх болон захиалагчтай зөвшилцөн өрж өгнө. Хараагүй хүнд зориулсан хавтанг 150см өргөнтэй явган замд 30см өргөнтэйгээр буюу нэг эгнээ, 2000см дээш өргөнтэй явган замтай хэсэгт 60см буюу хоёр эгнээ хөтөч хавтанг стандартын дагуу явган замын голоор хийнэ. Нарийвчилсан зургаас үзнэ үү.

Явган хүний замын 100 х 200 х 60 -н хавтанг өрж байрлуулах



Зураг 6.

Хөтөч хавтангийн хоёр талаар өнгөт хавтанг төлөвлөсөн. Хавтангийн доор 10см-н элсэн дэвсгэр байна. Явган хүний гарцан дээр анхааруулах хавтанг хийж өгнө.




Зураг 7.





**Хашлага.** Авто замын дагууд нь 180x1000x300мм-н хашлага тавина. Явган хүний замын захад 80x20x500мм-ийн жижиг хашлагыг босоогоор нь тавина. Дэлгэрэнгүйг нарийвчилсан зургаас

үзнэ үү.




Зураг 8.

**Хайс.**

Орон сууц хороолол дотор аюулгүй байдлыг бодолцон хайс төлөвлөлөө.

- 1. Хайсыг авто замын хашлагаас 10см зайтай явган хүний замын гадаргуугаас 1050см өндөртэй байхаар байрлуулна.
- 2. Хайс нь зэвэрдэггүй материал байна.
- 3. Хайсыг өнгө үзэмж чанарыг алдагдуулахгүйгээр захиалагч, зөвлөхтэй зөвшилцсөний дагуу өөр хайс хийж болно.



Зураг 9.



### 2.8 Хороолол дундах хүүхдийн тоглоомын талбай


Хүүхдийн тоглоомын талбайн тохижилтыг дараах газруудад хийхээр төлөвлөлөө. Үүнд:

- С-29, С-80, С-78 дугаар байрны урд
- 4-р багийн хорооллын дотор
- А-28 дугаар байрны урд
- Сангийн аж ахуйн орон сууцны дотор

Тус тоглоомын талбайг тохижуулахдаа фото зурагтай ижил буюу илүү сайн чанарын тоглоомыг захиалагчтай зөвшилцөн байрлуулж болно.

Хүүхдийн тоглоом, чийрэгжүүлэх тоног төхөөрөмж нь хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангахуйц стандартад нийцсэн байна.

- С-29, С-80, С-78 дугаар байрны урдах тоглоомын талбай



Зураг 10.












2.9 Ус зайлуулах байгууламж

2.9.1 Ус зайлуулах хоолой

Их тойруугийн авто зам дээр дөрвөлжин 1x1м т.б хоолой дараах 3 байрлалд төлөвлөв. /Км 1+520, Км 2+940, Км 3+980/


Зураг15.





Шинэ Өндөрхааны тойргийн авто зам дээр  $D=1.0\text{м}$  төмөр бетон хоолой Км 0+840 байрлалд төлөвлөв.

Зураг 16.









Гадаргын ус зайлуулах байгууламжийн нэг мянгийн зураг

Зураг 20.

ЗАМГАДАРТЫН УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ  
ХӨНДЛӨН СГТЛӨЛ









Орон сууцны хороолол дундах 4р зам, 6р зам гадаруугийн усыг U хэлбэрийн бүтээцээр цугласан усыг шүүрүүлэх худагт хуримтлуулж газарт нь шингээнэ гэж төлөвлөв. Шүүрүүлэх худгийг Зураг 21д үзүүлэв. Ус шүүрүүлэх худгийн ус шүүрүүлэх үед хэрэглэгдэх материал нь шаварлагын агууламжгүй хатуу буюу буталсан чулуун 250мм шигшүүрээр үлдсэн болон өнгөрсөн фракци бүхий хайрга, дайрга байна. Зорчих хэсгийн гадаргуун усыг зайлуулж хөндлөн гарж буй хэсэгт U хэлбэрийн бетон бүтээцийг барилгын ажлын үед явган замыг уялдуулж хийнэ.

Зураг 21




Зураг 22






Эрчимийн гудамж буюу 8р зам дээр гадаргуугийн усыг зорчих хэсгийн ирмэг дэх шүүрт худаг байрлуулж цугласан усыг шүүрүүлэх худагт хуримтлуулж газарт нь шингээх төлөвлөв. Шүүрт худагийг зураг 23д тусгав. Зураг 23



Холбооны гудамж буюу 5р зам, Сангийн аж ахуй буюу 9р зам дээр гадаргуугийн усыг цуглуулах худагт цугларна гэж төлөвлөв. Худагт дүүрсэн усыг соруулж зайлуулах шаардлагатай. Цуглуулах худагийн зураг 24д үзүүлэв

Зураг 24





2.10 Автомашины зогсоолын талбайн байрлал

Хангамжийн гудамжны 0.97км авто зам:

Хүснэгт 26.

д/д	Байрлал	Зүүн	Баруун
1	Км 0+212.7 – Км 0+252	+	-

2.11 Автобусны зогсоолын талбай

Шинэ Өндөрхааны тойргийн 3.701км авто зам:

Хүснэгт 27.

д/д	Байрлал	Зүүн	Баруун
1	Км 0+580 – Км 0+625.0	+	-
2	Км 0+645 – Км 0+690.0	-	+
3	Км 1+220 – Км 1+265.0	+	-
4	Км 1+285 – Км 1+330.0	-	+
5	Км 1+865 – Км 1+910.0	+	-
6	Км 1+940 – Км 1+985.0	-	+
	Уулзвар №2		
7	Км 0+015– Км 0+065.0	+	-
8	Км 0+115 – Км 0+160.0	-	+
	Уулзвар №3		
9	Км 0+001– Км 0+046.0	+	-
10	Км 0+091 – Км 0+136.0	-	+


Эрчмийн гудамжны 1.203км авто зам:

Хүснэгт 28.

д/д	Байрлал	Зүүн	Баруун
1	Км 0+120 – Км 0+165.0	+	-
2	Км 0+555 – Км 0+600.0	+	-

Зогсоолын талбай

Зураг 23.





2.12 Орц гарц

Авто замуудад шаардлагатай боломжит газруудад орц гарцыг төлөвлөж өгсөн бөгөөд гарцын төгсгөлд авто замын хашлагыг хэвтүүлж хийж өгнө.

Мөн айлуудын хаалгаруу орох орцыг асфальтбетон хучилтын хийцтэйгээр хийхээр төлөвлөсөн ба ногоон байгууламжтай тохиолдолд унагасан хэсгийг бетоноор, хашлагыг хэвтүүлж хийнэ. Дараах зургаас харна уу.




Айлууд руу орох орц гарцны хэсэгт явган хүний замын дагуу налууг хамгийн багадаа 1:20 налуутайгаар зорчих хэсэгтэй нэг түвшинд болгон налууулж БНБД 32 01 04, БД 31-101-04, MNS 6056 : 2009, MNS 5682 : 2006, MNS 5683 : 2016 стандарт болон норм дүрмийг баримтлан хийнэ үү.

Зураг 24.

Айлууд руу орох орц

Зураг 25.









Айлууд руу орох орц /дугуйн замтай үед/

Зураг 26.




Айлууд руу орох орц /ногоон байгууламжтай үед/

Зураг 27.




Явган хүний гарцны тэмдэглэгээг МУ-ын стандарт MNS 4696:2014 дагуу төлөвлөсөн болно.

Зураг 28.



$V < 60 \text{ Km/Hr}, P > 3.0$      $V > 60 \text{ Km/Hr}, P > 4.00$

1.13a. ЯВГАН ХҮНИЙ ЗОХИЦУУЛДАГГҮЙ ГАРЦ




1.136. ЯВГАН ХҮНИЙ ЗОХИЦУУЛДАГГҮЙ ГАРЦ

Явган хүний гарцны хэсэгт явган замын хавтанг хэвтүүлж хийх бөгөөд уулзвар хэсэг дэх буюу хоёр эгнээ 6м тэмдэглэгээтэй хэсэгт 3м өргөнтэйгөөр хэвтүүлж хийнэ. Харин нэг эгнээ буюу 3м гарцны тэмдэглэгээтэй хэсэгт 2м өргөнтэйгөөр явган хүний хавтанг хэвтүүлэн хийхээр төлөвлөсөн болно.

6м өргөнтэй үед:


Зураг 29.





3 м өргөнтэй үед:

Зураг 30.





